

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### **Дизель түлшний ерөнхий шаардлага:**

Монгол улсын MNS 0216:2017 стандартын шаардлагыг хангасан байна.

Зориулалт, хэрэглээ:

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй “Баянтээг” ТӨҮГ-ын дизелийн түлшээр ажилладаг хөдөлгүүртэй тээврийн хэрэгслүүд, өөрөө явагч болон хүнд машин механизм, бусад зориулалтын ижил төрлийн хөдөлгүүртэй тоног төхөөрөмжүүдийг ажиллуулахад ашиглана.

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт	
		Зуны улирлын (З)	Өвлийн улирлын (Ө)
1	Ангилал	А, В, С, D бүгд	2, 3
2	Цетаны тоо, багагүй	51	47
3	Хувийн жин, г/см <sup>3</sup>	0.820-0.845	
4	Шүүгдэх чанарын дээд температур °C, ихгүй	+5	-32
5	Булингартах температур °C, ихгүй	-	-22
6	Битүү тигельд дөл үүсгэх температур, °C, ихгүй	+55	+30
7	Түлшин дэх хүхрийн массын хувь, мг/кг, ихгүй	350	
8	Үнсжилт, массын %, ихгүй	0,01	
9	Усны агууламж, мг/кг, ихгүй	200	
10	Нийт бохирдол мг/кг, ихгүй	24	
11	Зэс хавтгайн туршилт (50°C температурт 3 цаг)	Тэсвэртэй	
12	Кинематик зууралдлага (40°C температурт мм <sup>2</sup> /с)	2000-4500	1400-4000
13	Түлшний төлөв	Шингэн	

#### **Нэмэлт шаардлага:**

1	Нийлүүлэх дизель түлш нь дээрх техникийн үзүүлэлтэд тодорхойлогдоогүй болон стандартаас зөрсөн тохиолдолд Монгол Улсын MNS 0216:2017 стандартаар батлагдсан хүснэгт 1, 2, 3-т тодорхойлсон дизель түлшний шаардлага, үзүүлэлтийг үндэслэл болгоно.
---	--

2	<i>Үйлдвэрлэгч нь дизель түлшинд цахилгаан цэнэг үүсэхээс хамгаалах зориулалттай бодисоос бусад металл агуулсан нэмэлт бодис хольж болохгүй.</i>
3	<i>Нийлүүлэгч /импортлогч, борлуулагч мөн адил/ нь түлшинд чанар сайжруулагч нэмж, хольж болохгүй.</i>
4	<i>Нийлүүлэхээр санал болгож буй түлшийг техникийн шаардлагад нийцэх эсэхийг тодорхойлох зорилгоор үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ, барааны тохирлын гэрчилгээ, магадлан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ.</i>
5	<i>Нийлүүлэх дизель түлш нь 2024 оны 01 дүгээр сараас хойш үйлдвэрлэгдсэн байна.</i>